

## ГОВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ХҮН АМЫН НУТАГШИЛ, СУУРЬШИЛ

Б.Батбуян, Д.Хишигдорж

ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Нийгэм эдийн засгийн газарзүйн сектор  
Э-шуудан: d\_dorjoo86@yahoo.com

### Abstract

Under the three magnets law the mechanism of pull-push the process of urbanization is rapidly increasing and as result of it the role and function some settlement has changed. The increase of population of the big cities has effect on increases the radius of influence of the settlement to surrounding area. This research work has held at four aimags. There is better infrastructure systems such as the development of mining and other services and they have tar roads and railways as well as bordering China is also a key of the population attraction.

**Түлхүүр үг:** Суурин газар, хүн амын нутагшилт, хот орчмын бүс нутаг

### Оршил

Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод бүс нутаг, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, хот хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана гэсэн тэргүүлэх чиглэлтэй [17] боловч том нутаг дэвсгэрийн цөөн хүн ам нь сийрэг суурьшсан, дэд бүтцийн хөгжил муу, хотжилт сул [12] улсад нийгэм эдийн засгийн хөгжил авчрахад туйлын хэцүү [1] байна. Гэвч суурьжилүүдэд дэд бүтэц, уул уурхайн үйл ажиллагааны нөлөөн дор говийн бүс нутаг руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн идэвхтэй явагдаж [7], жижиг суурин газрууд томорч байна. Тухайлбал энэ бүсэд 2000 онд 500 хүртэл хүн амтай жижиг суурин газрын тоо 18 байсан бол 2013 онд 11 болж цөөрчээ.

Хүн оршин суух том, бага суурин газрын бүх сүлжээг хүн амын нутагшилт гэдэгтэй олон судлаачид санал нэгдэж байгаа ч нутагшлыг суурьшилтай хамт тайлбарлах хандлага бий болж байна. Тухайлбал хөдөөгийн хүн амын суурьшил эрхлэх аж ахуй, бөөгнөрөн аж төрж буй хэлбэрээр нь газар тариалан-мал аж ахуй эрхэлсэн өрхүүдийн тогтвортой суурьшил, хот, хот маягийн суурин газрууд болон төмөр зам дагасан бэлчээрийн мал аж ахуй эрхэлсэн өрхүүдийн тогтвортой суурьшил, бэлчээрийн мал аж ахуйтай, хүн амын хөгжлийн зохистой нутагшил хамрагдаагүй малчин өрхүүдийн суурьшилд тэмүүлж байгаа малчид [1] гэж ангийн бол дээрх судлаачдын ангилал болон хүн амын амьдралын хэв маяг дээр тулгуурлан Улаанбаатар хотын Тэрэлж тосгоны хүн амын суурьшлыг жилийн дөрвөн үеийн амьдардаг, ажил хөдөлмөр эрхэлдэг болон том хотоос зундаа ирж зусдаг, улсдаа чанартай аж ахуй эрхэлдэг тогтвортой суурьшил, зундаа ирж зусан, бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг малчин өрхүүдийн тогтворжих суурьшил гэж [10] тодорхойлжээ.

Иймд суурин газрууд томрох болон жижигрэх явцад өөрчлөгдөж буй хүн амын нутагшил, суурьшлыг судалж, нэг төвт тогтолцооноос олон төвт тогтолцооноос шилжүүлэн хөгжүүлэх чухал шаардлагатай [1] байна.

Энэхүү өгүүлэлд хүн амын нутагшил, суурьшлыг зөв зохистой төлөвлөх асуудлыг хурцаар тавигдаж [14] байгаа говийн бүсэд суурин газрын байршилтаас харахад

өөрчлөгдөж буй хүн амын нутагшил суурьшлын хэлбэрүүдийг тодорхойлох оролдлого хийсэн болно.

### Судалгааны таамаглал

- Том хотын ойр орших суурин газруудын хүн ам буурч, улс орны нийгэм эдийн засагт зөвхөн малчдад үйлчлэх засаг захиргааны үүрэг гүйцэтгэж байна.
- Том хот болон тэнхлэгээс хол орших суурин газрууд өөрсдөө бие даан хөгжиж, хөрш зэргэлдээ орших суурин газруудаа татаж байна.
- Малчин өрхийн гишүүдийн зарим нь (эхнэр, хүүхдүүд) хүүхдүүддээ боловсрол эзэмшүүлэх үүднээс суурин газарт оршин сууж, хүн амын суурьшлын нэг хандлагыг бий болгож байна.

### Судалгааны аргазүй

Уг судалгаа нь Монгол орны нийт нутгийн 23 хувийг эзэлсэн, дэд бүтэц, уул уурхайн хөгжлийн нөлөөн дор хүн амын шилжих хөдөлгөөн идэвхтэй явагдаж буй Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн 47 сумыг хамарсан бөгөөд БНХАУ-тай хиллэдэг гол бүс нутаг юм. Үндсэн хуулинд хот, тосгон гэсэн ухагдахуун байхгүй тул аймгийн төв, сумын төвийг суурин газар гэж нэрлэв. Суурин газруудыг оршин суугчдын тоогоор жижиг, дунд, том [3] гэж ангилах нь хамгийн түгээмэл арга тул 1000 хүртэл хүн амтай суурин газрыг жижиг, 1000-5000 хүн амтайг дунд, 5000-аас олон хүн амтайг том суурин газар [13] гэсэн ангиллыг баримтлав. 2008 онд хэвлэгдсэн Монгол Улсын Үндэсний Атласын материал болон 2013 оны статистик тоон мэдээллийг суурь он болгон авав. Том суурин газрын үйлчлэх хүрээ буюу хүн амыг татах орон зайг хүн амын тоонд тулгуурлан зах зээлийн хүрээг илрүүлэх аргачлалыг [4] ашиглан тооцоолсон. Суурин газрын тэлэлтийг тодруулах судалгааг жижиг суурин газар (сумын төв)-ын гэр хорооллын хашаа, хорооны бүртгэлийг хийн, бүдүүвч зурагт буулган, Google earth-н агаар сансрын зурагтай давхцуулж, ArcGIS программыг ашиглан гэр хорооллын зураг зохиох дарааллаар хийсэн болно. Мөн санамсаргүй түүврийн аргаар сонгосон 80 гаруй өрхийн асуулгын материалд дүн шинжилгээ хийсэн.

### Судалгаанд хамрагдсан нутгийн тойм

Судалгааны нутагт манай улсын хүн амын 6.2 хувь (181.1 мянга) нь ажиллаж амьдарна. Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5.2 хувь (41.7 хувийг аж үйлдвэр, 31.7 хувийг үйлчилгээ, 26.6 хувийг хөдөө аж ахуй)-ийг үйлдвэрлэх ба нийт ажиллагсдын 53.3 хувь нь хөдөө аж ахуй, 9 хувь нь аж үйлдвэр, 37.7 хувь нь үйлчилгээний салбарт ажиллаж байна.


Хүн амын 66.8 хувь (121 мянга) суурин газарт оршин сууж байгаагаас 35.4 хувь (64.1 мянга) аймгийн төвд, 31.4 хувь (56.9 мянга) сумын төвд амьдарна. Том суурин 6 (12.8%), дунд суурин 11 (23.4%), жижиг суурин 30 (63.8%) байна. Суурин газруудын 7 хувь (3) нь аймгийн төвөөс 40 хүртэл км-т, 13.9 хувь (6) нь 40-80 км-т, 79.1 хувь (34) нь 80-аас дээш км-т оршино. Хатуу хучилттай авто зам дээр 14 (29.8%) суурин газар орших бол 8 (17%) сумын нутгаар хатуу хучилттай авто зам дайрна. Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс, Дорноговь аймгийн Мандах суманд стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газрууд байдаг.

**Үр дүн**

**Хүн амын тооны өөрчлөлт**

2006-2013 онд судалгааны нутгийн хүн ам 11.3 хувь (МУ-ын хүн ам 11.4 хувь)-иар өссөн байхад суурин газрын хүн ам 26.4 хувь (МУ-ын суурин газрын хүн ам 17.7 хувь)-иар өсчээ. Суурин газрын хүн амын өсөлт нийт хүн амын өсөлтөөс илүү байгаа нь гаднаас нэлээдгүй хүн ам уул уурхайн төвүүд, томоохон хот руу шилжин ирж байгаагаас гадна малчид суурин газар руу шилжин суурьшиж буйтай холбоотой [16] юм. Иймдээ ч малчдын тоо жил ирэх тутам буурч (24.9 хувь) байна.

Суурин газрын хүн ам өсч буй боловч нийгэм эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгаалж өсөлт нь харилцан адилгүй байна. Тухайлбал 2006 онтой харьцуулахад 2013 онд 33 суурин газар (70.2%)-ын хүн ам өсч, 14 суурингийн (29.8%)-х буурчээ (1 дүгээр зураг).



1 дүгээр зураг. Хүн амын тооны өөрчлөлт

(Эх сурвалж: Аймгуудын статистикийн эмхэтгэл 2006, 2013)

Хүн ам өссөн суурин газрын 39.4 хувь (13) Өмнөговь аймагт, 30.4 хувь (10) Дундговь аймагт, 24.2 хувь (8) Дорноговь аймагт, 6 хувь (2) Говьсүмбэр аймагт (1 дүгээр зураг) байна.

**Том суурин газрын алслалтаас хамаарсан хүн амын нутагшилт**

Том суурин руу ойртох тусам суурин газрын хүн амын өсөлтийн хувь бүрэн зүй тогтол ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл алслагдсан суурин газрын хүн ам том сууринтай ойролцоо буюу 40 хүртэл км зайд орших суурин газрын хүн амын өсөлттэй (1 дүгээр хүснэгт) байна.

1 дүгээр хүснэгт. Хүн амын тооны өөрчлөлт (2006-2013)

Том суурин газраас алслагдсан зай	Сумын нийт хүн амд суурин газрын хүн амын эзлэх хувь (2013)	Хүн амын тооны өөрчлөлт (хувиар)		
		Нийт	Суурин газар	Хөдөө
Том суурин	92.9	19.5	16.1	94.4
40 хүртэл км	54.8	6.1	6.1	6.2
40-80 км	36.4	-14	18	-25.6
80-аас дээш км	52.2	9.9	46	-13.5
<b>Бүгд</b>	<b>66.8</b>	<b>11.3</b>	<b>26.4</b>	<b>-10.4</b>

(Эх сурвалж: Аймгуудын статистикийн эмхэтгэл 2006, 2013)


Харин хөдөөгийн хүн ам эсрэгээрээ том суурин руу ойртох тусам өсч, алслагдсах тутам буурч (1 дүгээр хүснэгт) байна. Тухайлбал хээрийн судалгаанд хамрагдсан Өмнөговь аймгийн Ханхонгор сумын суурин газрын хүн ам тайлант онд 45 хувиар буурч, хөдөөгийн хүн ам 31.9 хувиар (2 дугаар зураг) өсчээ.

Ханхонгор сум

Сумын төвд 777, хөдөөд 1336 хүн амьдардаг. Аймгийн төвөөс 25 км, Улаанбаатар хотоос 532 км алслагдсан, сумын нутаг дэсвгэрт 14 аж ахуйн нэгж, 15 жуулчны бааз үйл ажиллагаа явуулдаг. 2014 онд Нийслэл Улаанбаатарыг Даланзадгад хоттой холбосон хатуу хучилттай зам сумын нутгийг дайран өнгөрч, 2012 онд төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Соёл урлагийн төрөлжсөн сургалттай 220 хүүхдийн багтаамжтай 12 жилийн сургуультай.

Суурин газрын тэлэлтийг тодруулах судалгаагаар 2007 оноос хойш нүүж явсан 12 айлын байшингийн туурь үлджээ. Судалгаанд хамрагдсан 56 хашаа эзэмшигчийн бүртгэлээр 75 хувь (42 өрх) нь уугуул болон 2007 оноос өмнө шилжиж ирсэн, 21.4 хувь (12 өрх) нь 2007-2014 онд шилжиж ирсэн, 3.6 хувь (2 өрх) нь шинээр гэр бүл болсон айл байлаа. Дээрх 56 хашаанд 79 өрх амьдрах ба 11 өрх өөрийн гэсэн хашаагүй, хүний буюу танил найз нөхөд, ах дүүгийнхээ хашаанд хамтдаа амьдарч байна. Нийт өрхийн 96.2 хувь (76 өрх) нь жилийн турш амьдардаг, 3.8 хувь (3 өрх) нь зөвхөн өвлийн улиралд их гэрээрээ ирж өвөлждөг (өрхийн гишүүний аль нэг нь бага гэрээрээ өвөлжөөн дээр мал аж ахуйгаа эрхэлдэг) малтай өрхүүд байна.

## Өмнөговь аймгийн Ханхонгор сум-Аймгийн төвтэй ойр



2 дугаар зураг. Өмнөговь аймгийн Ханхонгор сумын төвийн хүн амын нутагшилт Эх сурвалж: Хээрийн судалгааны материал 2014

Тухайн суурин газар сумын малчдадаа хүрч үйлчилж чадаж байгаа эсэхийг тодруулахаар хөдөөгийн 20 малчин өрхөөс асуулга судалгаа авахад 30 хувь нь өрх тасарч амьдардаг байна. Үүний 83.3 хувь хүүхдүүддээ боловсрол эзэмшүүлэхийн тулд өрх тасардгаас 60 хувь нь аймгийн төвд, 40 хувь нь сумын төв, Улаанбаатарт амьдарч байна. Гэр бүлийн зориулалтаар газар өмчилж авсан уу гэж асуухад 25 хувь нь тийм гэсэн хариулт өгсөн ба 80 хувь нь аймгийн төв дээр өмчилжээ. Энэ нь тухайн суурин газар үүргээ гүйцэтгэж чадахгүй, хүн ам аймгийн төв рүү татагдаж буйг харуулж байна.

### Тэнхлэгээс алслалтаас хамаарсан хүн амын нутагшилт

Тэнхлэгээс алслагдах тусам суурин газрын хүн амын өсөлтийн хувь буурч байна. Тухайлбал тайлант онд тэнхлэг дээр орших суурин газрын хүн ам 27.9 хувь, тэнхлэг суурин газрыг дайраагүй боловч сумын нутгаар нь дайрч байгаа сумын суурин газрын хүн ам 50.1 хувь (Хүснэгт 2), тэнхлэг суурин газар болон сумын нутгийг огт дайраагүй сумын суурин газрын хүн ам 7.1 хувиар тус тус өсчээ. Тэнхлэг дайран өнгөрч буй сумдын хөршийн эрэмбээр тэнхлэг дайраагүй сумуудыг задлахад 2-р эрэмбийн хөрш сумуудын суурин газрын хүн амын өсөлтийн хувь нь 1-р эрэмбийн хөрш сумдын суурин газрын хүн амын өсөлтийн хувиас бараг 5 дахин буюу тэнхлэг дээр орших суурин газрын хүн амын өсөлтийн хувьтай бараг ойролцоо 25.6 хувь (2 дугаар хүснэгт) байна. Харин хөдөөгийн хүн тэнхлэг дээр орших суманд өсч, эсрэгээр бусад сумдад буурчээ.

2 дугаар хүснэгт. Хүн амын тооны өөрчлөлт (2006-2013)

Суурин газрын байрлал	Сумын нийт хүн амд суурин газрын хүн амын эзлэх хувь (2013)	Хүн амын тооны өөрчлөлт (хувиар)		
		Нийт	Суурин газар	Хөдөө
Тэнхлэг дээр орших	86.9	24.7	27.9	7
Тэнхлэг сумын нутгаар нь дайрсан	52.6	9.7	50.1	-15.5
Тэнхлэг дайрсан сумтай хөрш	29.9	-9.3	5.1	-14.3
Тэнхлэг дайрсан сумын 2-р эрэмбийн хөрш	33.7	-5.1	25.6	-15.6
<b>Бүгд</b>	<b>66.8</b>	<b>11.3</b>	<b>26.4</b>	<b>-10.4</b>

Эх сурвалж: Аймгуудын статистикийн эмхэтгэл 2006, 2013

Тухайлбал хээрийн судалгаанд хамрагдсан Дундговь аймгийн Өндөршил сумын хөдөөгийн хүн ам тайлант онд 30.2 хувиар буурч, суурин газрын хүн ам 15.7 (3 дугаар зураг) өсчээ.

### Өндөршил сум


Сумын төвд 782, хөдөөд 693 хүн амьдардаг. Аймгийн төвөөс 182 км, Улаанбаатар, Сайншандын хатуу хучилттай авто замаас 135 км алслагдсан. Төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. 9 жилийн ЕБС-тай.

### Дундговь аймгийн Өндөршил сум



Судалгаанд хамрагдсан өрхийн шилжих хөдөлгөөнд оролцсон байдал

Өрхийн тоо	Өрхийн төрөл			2007 оноос хойш шилжих явсан өрхийн тоо
	Уугуул өрх	2007-2013 онд шилжих ирсэн өрх	2014 онд шилжих ирсэн өрх	
145	85.6%	10.3%	4.1%	2



Өрхийн сууцны төрөл



Суурьшлын хэлбэр



Хөдөөгийн суурь

3 дугаар зураг. Дундговь аймгийн Өндөршил сумын төвийн хүн амын нутагшилт, Эх сурвалж: Хээрийн судалгааны материал 2014

Суурин газрын тэлэлтийг тодруулах судалгаагаар 2007 оноос хойш нүүж явсан 2 айлын байшингийн туурь үлджээ. 146 хашааны эзэмшигчийн бүртгэлийг хийхэд 85.6 хувь (125 өрх) нь уугуул болон 2007 оноос өмнө шилжиж ирсэн, 10.3 хувь (15 өрх) нь 2007-2013 онд шилжиж ирсэн, 4.1 хувь (6 өрх) нь 2014 онд шилжиж ирсэн айл байлаа. Дээрх хашааны 10.3 хувь (15 хашаа)-д хүн амьдардаггүй. Үлдсэн 131 хашаа, 6 хашаа хатгаагүй талбайд 172 өрх амьдрах ба 93 хувь (160 өрх) нь жилийн турш амьдардаг, 7 хувь (12 өрх) нь зөвхөн өвлийн улиралд их гэрээрээ ирж өвөлждөг малтай өрхүүд байна. Хөдөөгийн 21 малчин өрхөөс асуулга судалгаа авахад 66.7 хувь нь сургуулийн насны хүүхэдтэй байна. Үүний 42.9 хувь хүүхдүүдээ боловсрол эзэмшүүлэхийн тулд өрх тасрах ба 83.3 хувь нь сумын төвд амьдарна. 57.1 хувь нь гэр бүлийн зориулалтаар газар өмчилж авснаас 100 хувь сумын төв дээр өмчилжээ. Энэ нь тухайн суурин газар аймгийн төв болон тэнхлэгээс хэт алслагдсан ч өөрөө бие даан хөгжиж буйг харуулж байна.

### Уул уурхайгаас хамаарсан хүн амын нутагшилт

Судалгааны бүс нутгийн ихэнх суманд их бага хэмжээний орд уурхай үйл ажиллагаа явуулах боловч 8 суманд стратегийн ач холбогдол бүхий, 7 суманд стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордод бүртгүүлэх санал хүргүүлсэн уурхай оршиж байна. Стратегийн орд уурхайтай болон уурхайгүй суманд суурин газрын хүн ам өсч байхад эсрэгээр хөдөөгийн хүн ам буурч (3 дугаар хүснэгт) байна. Харин стратегийн ордод орох санал хүргэгдсэн суманд суурин газрын хүн ам буурч, хөдөөгийн хүн ам өсчээ (3 дугаар хүснэгт). Энэ нь уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр малын бэлчээр, малчдын нүүдлийн зай хумигдсанаар хөрш зэргэлдээ сумууд руу, байгалийн зохистой бүс нутаг руу [5] нүүдэллэж буйтай холбоотой.

3 дугаар хүснэгт. Хүн амын тооны өөрчлөлт (2006-2013)

Уурхайн төрөл	Сумын нийт хүн амд суурин газрын хүн амын эзлэх хувь (2013)	Хүн амын тооны өөрчлөлт (хувиар)		
		Нийт	Суурин газар	Хөдөө
Стратегийн ач холбогдолтой уурхайтай сум	59	30.5	95.2	-11.7
Стратегид орох санал хүргэгдсэн уурхайтай сум	62.1	-1.3	-16.5	40.1
Уурхайгүй сум	69.4	10.7	30.5	-17.5
<b>Бүгд</b>	<b>66.8</b>	<b>11.3</b>	<b>26.4</b>	<b>-10.4</b>

Эх сурвалж: Аймгуудын статистикийн эмхэтгэл 2006, 2013

Тухайлбал бидний судалгаанд хамрагдсан стратегийн ач холбогдолтой орд оршдог Цотцэций сумын төвийн хүн ам тайлант онд 545.1 хувиар өсч, 5380 хүнтэй том суурин болжээ. Тус сумын 19 малчин өрхөөс асуулга судалгаа авахад 57.9 хувь нь сургуулийн насны хүүхэдтэй ба 90.9 хувь нь сумын сургуульдаа суралцаж байхад дөнгөж 1 өрх л хүүхдэдээ боловсрол эзэмшүүлэх үүднээс өрх тасарч амьдарч байна. 84.2 хувь нь гэр бүлийн зориулалтаар газар өмчилж авснаас 100 хувь суман дээрээ авчээ. 90.9 хувь нь ахуйн хэрэгцээний бүтээгдэхүүнээ сумын төвөөс худалдан авдаг гэж хариулжээ.

4 дүгээр хүснэгт. Сумын нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Сумын нэр	Аймгийн төвөөс алслагдсан зай (км)	Хүн ам	Хүн амын тооны өөрчлөлт (2000-2013)			Нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь	Дэд бүтэц		Боловсрол		Төсвийн орлого, зарлагын харьцаа	Аж ахуй нэгж байгууллагын тоо
			Нийт хүн ам	Суурин газар	Хөдөө		Авто зам	Үүрэн телефон	ЕБС-ийн төрөл	ЕБС-ийн бохир жин		
Цогтцэций	100	6108	+	+	-	10.9	-	4	БД	103.8	+	437
Манлай	230	2522	+	+	-	65.3	-	4	ББД	79.1	-	30

Эх сурвалж: Сумын танилцуулга 2013

Цогтцэций сумтай 1-р эрэмбийн хөрш, орд уурхай байхгүй Манлай сумын зарим нэг нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг тус сумтай харьцуулж үзвэл нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь 6 дахин илүү, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалтын бохир жин 1.3 дахин бага (4 дүгээр хүснэгт) байна. Харин Цогтцэций сум өөрийн сумын сургуулийн насны хүүхдүүдээс гадна хил залгаа сумдын хүүхдүүдийг сургаж (103.8 хувь) байна (4 дүгээр хүснэгт).

**Хүн амын нутагшил, суурьшлын хэлбэрүүд**

Хүн амын нутагшил суурьшил нь хүн ам нутаг дэвсгэрээр тархан суурьшихдаа чухам амьдралын ямар хэв маягаар, ямар аж ахуй эрхэлж, хэрхэн бөөгнөрөн аж төрж байгааг харуулах [8] тул гэр хорооллын тэлэлтийг тодруулах судалгаан дээр үндэслэн говийн бүсийн хүн амын суурьшлын дөрвөн хэлбэр байгааг тодорхойллоо.

- Жилийн дөрвөн улиралд амьдардаг, ажил хөдөлмөр эрхэлдэг, өөрийн гэсэн эзэмшил хашаатай өрхүүдийн **байнгын тогтвортой суурьшил** (нийт өрхийн 69.1%-219 өрх)
- Жилийн дөрвөн улиралд амьдардаг, ажил хөдөлмөр эрхэлдэг боловч өөрийн гэсэн эзэмшил хашаагүй, ямар нэгэн зүйл тохиолдоход шилжих хөдөлгөөнд оролцоход бэлэн буй өрхүүдийн **тогтвортой суурьшил** (нийт өрхийн 23.9%-76 өрх)
- Хүүхэд багачууддаа боловсрол эзэмшүүлэх, ажил хөдөлмөр хийхээр өрх тасран амьдардаг, өөрийн гэсэн эзэмшил хашаатай, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчин өрхүүдийн **тогтворжих суурьшил** (нийт өрхийн 3.2%-10 өрх)
- Хүүхэд багачууддаа боловсрол эзэмшүүлэх үүднээс өвлийн улиралд өрх тасран амьдардаг, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчин өрхүүдийн **суурьшилд тэмүүлж буй малчид** (нийт өрхийн 3.8%-12 өрх)

**Хэлэлцүүлэг**

Томоохон хот орчмын бүс болж байгаа сумууд аймгийн бараг сумдаас малчин өрхүүд зах зээлд ойртох нүүдлээр ирэхэд тэдгээрийг хүлээн авдаг бамбай сум болж [1], эрчимгүй мал аж ахуй эрхлэх өрх аж ахуйтны тоог нэмж [11] байна. Энэ нь малчид том сууринг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр байнга найдвартай хангах, суурин газар нь малчдад үйлчлэх захиргааны үүрэг хүлээж байгаа бол нийгмийн үйлчилгээ



(боловсрол, эрүүл мэнд, шатахуун, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдаа, авах гм)-г том суурин газраас авч [9] байна. Эдгээр сууринг том суурингийн хүн ам, үйлдвэрлэлийн хэт бөөгнөрлийг сааруулах замаар дагуул хаяа хот болгож, байгалийн орчинд ээлтэй бага оврын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төв болгон хөгжүүлж байна. [6] юм. Ингэж улс орны эдийн засагт томоохон хотын зэргэлдээ орших жижиг сумын газрын нөлөө нэмэгдэнэ.

Томоохон хот болон аймгийн төвөөс алслагдсан бэлчээрийн малын экологийн бүрэн биш нутагтай, хүн ам цөөтэй, мал аж ахуйгаас өөр орлогогүй сумдын оршин суугчид нь хот суурин тийш их нүүдэл хийж өөрийн сумдаа өөрсдөө татан буулгах [11] байгаа мэт харагдаж буй боловч бүх сум, суурин газрууд жижгэрсэнгүй. Том суурин газрын хүрч үйлчилж чадахгүй байгаа хоосон орон зайг бөглөж, зэргэлдээ сум сумын газарт нийгмийн үйлчилгээ хүргэх үүрэгтэй төвийн байршилтыг хадгалсан, хотуудын гинжин холбоо үүсгэж байгаа суурин газрууд хүн амыг өөр дээрээ татан томруулах өөрөө бие даан хөгжиж [16] байна. Иймд том суурин, тэнхлэгээс алслагдсан сумын газарт газарзүйн байрлал, зам тээвэр, түлш, эрчим хүч, үйлдвэрийн түүхий эдийн засаг зэргээр аль давуутайг сонгож, хүн амын шилжих хөдөлгөөний гол шалтгаан болон үйлдвэрийн газрууд, сургууль, соёл, үйлчилгээний салбаруудыг хөгжүүлж байгаа суурин газрын үүргийг нэмэгдүүлэх шаардлага гарч [16] байна. Ингэхдээ малчдын уурхайн салбарын хөгжилтэй холбогдон тодорхой хэмжээний ажлын байр, суурин бий болж байгааг харгалзах шаардлагатайг харуулж байна.

Эндээс засаг захиргаа нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг шинээр зохионо. Шаардлага тулгарч байгааг харж болно. Тухайлбал хээрийн судалгаанд хамрагдсан Дундговь аймгийн Цагаандэлгэр сум нь Мандалговь хотын сул үйлчилгээний байр Улаанбаатар – Чойр хатуу хучилттай авто замаас 60 км зайд оршино. 2006 онд харьцуулахад 2013 онд тус сумын суурин газрын хүн ам 34.9 хувиар, хөдөөгийн хүн ам 46.9 хувиар тус тус буурчээ. Суурин газрын тэлэлтийг тодруулах судалгаанд 2007 оноос хойш нүүж явсан 14 өрхийн байшингийн туурь үлдсэн байсан ба 45 хувийн эзэмшигчийн бүртгэлийг хийхэд 97.8 хувь (45 өрх) нь уугуул, 2.2 хувь (1 өрх) нь шинээр гэр бүл болжээ. Энэ хугацаанд шилжиж ирсэн өрх байхгүй байлаа. Хөдөөгийн 17 малчин өрхөөс асуулга авахад 29.4 хувь нь гэр бүлийн зориулалтаар газраа өөрчлөх авсны 40 хувь нь сумын төвд, 60 хувь нь Говьсүмбэр аймгийн төв Чойрт өөрчлөх байна. Тус суурин газар нь Өндөршилтэй адил том суурингийн үйлчлэхгүй зайд, зам дээр оршдоггүй хэрнээ өөрөө бие даан хөгжиж чадахгүй байгаа нь Говьсүмбэр аймгийн төв Чойртой ойр, түүний хот орчмын бүс болж байгаагаар холбоотой юм. Иймдээ ч уг суурин газрын хүн ам аймаг дотроо хамгийн их буурч байна.

### Дүгнэлт

Бусад бүс нутагтай харьцуулахад говийн бүсэд суурин газрууд томорч буй байдал нийгэм эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгаалж бүх суурин газрууд томорч чадахгүй байна. Том суурингийн ойр орших сумууд нь хот орчмын бүс болж, суурин газар нь засаг захиргаа, хөдөө аж ахуйн үүргийг гүйцэтгэж, үйлчилгээний үүрэгтэй сууринд алдаж байхад том суурин, тэнхлэгээс алслагдсан зарим нэг жижиг сумын хүн амыг өөр дээрээ татан төвлөрүүлж, гүйцэтгэж буй үүргээ улам нэмэгдүүлж байна. Иймд эдгээр сууринг аж ахуйн төрөлжилтөөр нь хөгжүүлж, үүргийн бүтцийг асуу боловсронгуй болгох шаардлагатай байна. Ингэхдээ уул уурхайд тулгуурлан малчдын буй суурин болон нүүдлийн соёл иргэншлээс суурин соёл иргэншилд шилжих нь малчдын [1] тогтворжих суурьшил, суурьшилд тэмүүлж буй малчдын суурьшил харгалзах нь зүйтэй байна.

**Ашигласан материал**

1. Базаргүр, Д., Батбуян, Б., 2007. “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм эдийн засгийн газарзүйн тандах судалгаа” УБ
2. Гунгаадаш, Б., 1986. “БНМАУ-ын нийгэм эдийн засгийн газарзүй” УБ
3. Цэдэнсодном, Х., 1999. “Монголын хүн ам ба хүрээлэн буй орчин” УБ
4. Jean-Paul Rodrigue, Claude Comtois., 2006. “The geography transport system” New York
5. Оюунгэрэл, Ж., 2004. “Нийгэм эдийн засгийн шинэ нөхцөл дэх Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлууд” (PhD) УБ
6. Баянтөр, М., 2003. “Улаанбаатар хотын хүн амын өсөлт, хот орчмын зарим суурингийн үүргийн бүтцэд гарч буй өөрчлөлтүүд” Газарзүйн асуудлууд №3, УБ
7. Болормаа, Ц., 2011. “Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү: Байгаль орчин, ногоон хөгжил” Монголын хүний хөгжлийн илтгэл, УБ
8. Оюунгэрэл, Ж., 2005. “Монгол орны хүн амын байршил, нутагшилтанд шилжих хөдөлгөөний үр дүнд гарсан өөрчлөлт” Монгол орны газарзүйн асуудал №4, УБ
9. Хишигдорж, Д., 2014. “Хот орчмын бүс дэх жижиг суурин газрын үүргийн бүтэц” Монгол орны газарзүйн асуудал №10, УБ
10. Хишигдорж, Д., Урантамир, Г., бусад., 2015. “Хүн амын суурьшил, Тэрэлж суурин” Тэрэлж голын сав газар, геосистем, УБ
11. Чинбат, С., 2003. “Нийслэлийн хот орчмын хөдөөгийн бүсийн хөгжил, байршлын онцлог” Газарзүйн асуудлууд №3, УБ
12. Hinderink, J., Titus, M., 2001. “Small town and Regional development: Major findings and policy implications from comparative research” Urban studies 39
13. Баянтөр, М., Одхүү, Н., 2008. “Хот тосгоны ангилал” зураг МУ-ын үндэсний атлас
14. “Монгол Улсын ерөнхийлөгчийн илгээлт” 2010. Баруун бүсийн хөгжил, шинжлэх ухаан, технологи” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл УБ
15. “Хүний хөгжлийн илтгэл 2007” НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр УБ
16. “Монгол орны нийгэм эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх газарзүйн үндэслэл” сэдэвт ажлын тайлан (2008-2010)
17. www.legalinfo.mn